



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/45 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрэм” шинэчлэн батлагдсантай холбогдуулан Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/209 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны журам”-ын 1.1-т заасан “Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 2.1.1.1” гэсэн хэсгээс “2.1.1.1” гэж заасныг; мөн тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Холбоо, навигаци, ажиглалтын албаны журам”-ын 1.1-т заасан “Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 2.1.1.3” гэсэн хэсгээс “2.1.1.3” гэж заасныг; Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар батлагдсан “Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны журам”-ын 1.1-т заасан “Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 2.1.1.2” гэсэн хэсгээс “2.1.1.2” гэж заасныг тус тус хасаж өөрчлөлт оруулсугай.

2. Энэхүү тушаалыг мөрдөж ажиллахыг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба (П.Пүрэвсүх), Холбоо, навигаци, ажиглалтын алба (М.Эрдэнэсүх), Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба (П.Ариунгэрэл)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс (Л.Тайванжаргал)-т даалгасугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ